



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.02 № 01/710
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-
ЭРДЭНЭ СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ЖАНЛАВ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ардчилсан намын хорооны Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд

37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрт аудит хийхэд хуульд нийцээгүй зорилт, арга хэмжээ тусгасан нь хууль тогтоомжийн холбогдох шаардлагад нийцсэн гэх дүгнэлт гаргах боломжгүй байна.

Энэхүү дүгнэлтийн нэгдүгээр хавсралтад дурдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт нийцээгүй, хоёрдугаар хавсралтад дурдсан зорилт, арга хэмжээний эдийн засгийн үндэслэл тооцоо, судалгааг дутуу боловсруулж ирүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ардчилсан намын хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөрийн холбогдох зорилт, арга хэмжээний зөрчлийг арилгаж 2024 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн дотор дахин дүгнэлт гаргуулахаар ирүүлнэ.

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР




Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр

ҮНДСЭН ЧИГЛЭЛ : 2024-2028 онд Алаг-Эрдэнэ сумын Ардчилсан намаас сум орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг төсвийн байгууллагын бодлого хэрэгжилтийг дэмжиж , нийт иргэдийнхээ эрх ашгийг хангаж, Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Алсын хараа 2050 хөтөлбөр , Урт хугацааны хөгжлийн бодлого Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжсөн- Хөвсгөл 2030 хөтөлбөр, Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх иргэдээс ирсэн ажлын санал нарыг тулгуурлан мөрийн хөтөлбөрийг боловсруулахад чиглэсэн.

➤ Нэг: Эрүүл мэнд

- 1.1 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжихэд бүх талын хамтын ажиллагааг сайжруулах
- 1.2 Эх, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлүүдийг арилгаж “Эх, хүүхдэд ээлтэй” байгууллага, баг, сум болгох хөдөлгөөнийг өрнүүлэх
- 1.3 “Эх хүүхдийг эрсдэлээс хамгаалах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 1.4 Эм, вакцин био бэлдмэлийн аюулгүй байдлыг хангаж, сайн дурын дархлаажуулалтыг өргөжүүлж, товллын дархлаажуулалтын хямралыг сайжруулах
- 1.5 Хүн амыг аюулгүй ус, хүнсээр хангах, орчны ариун цэврийн байдлыг сайжруулахад чиглэсэн бодлогуудыг хэрэгжүүлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж чадавхыг сайжруулах
- 1.6 Хүний зан үйлтэй холбоотой өвчлөл/ хорт зуршил, осол гэмтэл, байгалийн голомтод өвчлөл /-өөс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг сайжруулж үр дүнд хүрэх
- 1.7 Архи тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлж, худалдааг бууруулах, архи тамхины хэрэглээг багасгах,
- 1.8 Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, хүний зан үйлтэй холбоотой өвчлөлөөс сэргийлэх ажилд иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх
- 1.9 Өрх гэрийн эрүүл мэндийг дэмжсэн хөтөлбөр гарган хэрэгжүүлэх
- 1.10 Байгууллага, аж ахуйн нэгж бүр эрүүл, аюулгүй эрсдэлгүй орчин бүрдүүлсэн байх
- 1.11 Эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлыг зохин байгуулж цэцэрлэгийн наснаас нь эхлэн иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх
- 1.12 Зайлшгүй шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх
- 1.13 Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадвар ёс зүй хариуцлагыг сайжруулах
- 1.14 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бий болгож хөгжүүлэх
- 1.15 Аж ахуйн нэгж байгууллагын ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах



0000000001

1.16 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж халдварт бус өвчин тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн хяналт тандалтыг сайжруулах эрүүл мэндийг дэмжих замаар хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс шалтгаалсан нас баралтыг бууруулах

1.17 Анхан шатны тусламжийг тогтвортой зохион байгуулж үйлчилгээний шуурхай нээлттэй байдлыг хангаж хэвшүүлэх

➤ **Хоёр: Боловсрол, соёл**

2.1 Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг ЕБС, СӨБ-д бүрэн хэрэгжүүлэх зорилт зорилгыг хангаж ажиллуулах

2.2 Судалгаа мэдээлэлд суурилсан хөгжлийн хөтөлбөр бодлого төлөвлөлтийг боловсруулах

2.3 Боловсролын удирдлага мэдээллийн системтэй болж баяжуулах ажлыг тогтмолжуулан суралцагчдыг шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах

2.4 Сургалтыг дэмжих үйл ажиллагааг хөгжүүлж экологийн боловсрол оюуны спорт, үндэсний урлаг, спортын хөтөлбөрийг хэрэгжүүлэх

2.5 Багшийн шинэ санаа арга технологи, туршлагыг үнэлэх, түгээн дэлгэрүүлэх тогтолцоог сайжруулах

2.6 Дотуур байрыг хүүхдийн сурч хөгжих, эрүүл аюулгүй ээлтэй орчин бий болгох

2.7 СӨБ-ийн сургалтын хөтөлбөрийг хүүхдийн онцлог шинжид тулгуурлан хэрэгжүүлэх

2.8 Цэцэрлэгийн бүлэг бүрийг стандартын шаардлага хангасан сургалтын техник хэрэгслээр хангаж, интернэт, камертай холбож ээлтэй орчин бүрдүүлэх

2.9 СӨБ-ийн багш нарыг мэдээлэл харилцааны технологийг ашиглан мэдлэг чадвараа дээшлүүлэх зайнаас суралцах туршлагаа хуваалцан ажиллах орчин нөхцөл бүрдүүлэх

2.10 Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үзэл баримтлал үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх

2.11 Хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, оюун санааны өсөлт хөгжлийн хяналтыг сайжруулах

2.12 Бага, суурь, бүрэн дунд боловсролын залгамж чанарыг сайжруулж, боловсролын стандарт сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

2.13 Байгалийн ухааны хичээлийг туршилт судалгаа хийх лабораторид түшиглэн сургалт зохион байгуулах орчин бүрдүүлэх

2.14 Хуучин спорт заалыг засварлаж сурагчдын бие тамирын хичээлээр хичээллэх боломжийг бүрдүүлэх

2.15 Сурагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн баялаг цахим номын сантай болох

2.16 Ахлах ангийн хүүхэд бүрийн авьяас сонирхолд тулгуурлан стандарт хөтөлбөрөөс давсан агуулгаар сургалт зохион байгуулах

2.17 Багшийн сайн хичээл арга технологиор сан бүрдүүлж гэрчилгээжүүлэн түгээн дэлгэрүүлдэг тогтолцоог бүрдүүлэх

2.18 Сурагчдад монгол ёс зан заншлын мэдлэг олгох

2.19 Иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ сонирхол авьяас чадвар хөгжлийн онцлогт нэгдсэн олон хувилбартай хөтөлбөрөөр үйлчилгээ үзүүлнэ

➤ **Гурав: Хөдөлмөр эрхлэлт**

00000000062

3.1 Сумандаа сүүний чиглэлийн ферм байгуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг бодлоор дэмжиж ажиллана.

3.2 Бяслэгийн үйлдвэрийг түшиглэж хуурай сүү, ааруул, эззгий, цагаан идээ гэх мэт хувийн хэвшлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх

3.3 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж эдийн засгийн өсөлтийг бий болгоно.

3.4 Иргэдийн хөдөлмөрлөх хүсэл санаачилгыг дэмжиж нөөц боломждоо тулгуурлан бүхий л талаар хамтран ажиллах

3.5 Хөдөлмөр эрхлэлтийн таатай орчныг бүрдүүлэх

3.6 Ажиллах хүчний эрэлтийг орон нутгаас хангах бодлого барина

3.7 Байгальд ээлтэй ажлын байрны үнэлэмжийг дээшлүүлж эдийн засгийн идэвхгүй хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх

3.8 Ажиллах хүчнийг мэргэшүүлж тогтвор суурьшилтай ажиллуулах

3.9 Нийтийн ахуйн үйлчилгээг бий болгож хуучин хүүхдийн цэцэрлэгийн байрыг засварлан төвлөрсөн халаалтад холбож ЖДҮ эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

➤ **Дөрөв : Нийгмийн халамж**

4.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой зохион байгуулж иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж хамтран ажиллах

4.2 Нийгмийн ажил үйлчилгээг цахимжуулж шат дамжлагыг цөөрүүлэх

4.3 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлнэ. 4.4 Хавтгайрсан халамжаас татгалзаж, халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү чиглүүлнэ.

4.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд оролцох орчин нөхцөлийг бүрдүүлнэ

4.6 Зорилтот бүлгийн өрхийг орлого, нэмэгдүүлэх нийгмийн олон талт арга хэмжээнд хамруулах замаар тогтвортой орлогын эх үүсвэртэй болгож өрхийн орлогыг нэмэгдүүлнэ

➤ **Тав: Санхүү, эдийн засаг**

5.1 Санхүү төсвийг хөгжлийн шаттай нийцүүлэн төсвийн тэнцвэртэй байдлыг хангаж орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ

5.2 Орлогын баазыг нэмэгдүүлж, төсвийн ил тод, оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ

5.3 Татвар төлөгчдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлнэ

5.4 Татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжийг зээлийн бодлогоор дэмжих

5.5 Банк бус санхүүгийн байгууллага үүсгэх санал санаачилгыг дэмжинэ


5.6 Даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

5.7 Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоог жил бүр нэмэгдүүлнэ

5.8 Нийгмийн даатгалын мэдээллийг цахимд шилжүүлэх

5.9 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, үр нөлөөг дээшлүүлнэ

➤ **Зургаа: Хөдөө аж ахуй**



Signature

00000000.13

- 6.1 Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана
- 6.2 Уламжлалт болон эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, халдварт, паразит өвчний гаралт тархалтыг бууруулан, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ
- 6.3 Малын тэжээл тариалах, бүрэн найрлагат тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих
- 6.4 Мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгох
- 6.5 Бэлчээрийг зохистой ашиглаж, хамгаалан сайжруулан даац багтаамжийг нэмэгдүүлэх
- 6.6 Бэлчээрийн хортон мэрэгчийг устгах ажилд малчид, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 6.7 Малчдын залгамж халааг нэмэгдүүлж, залуу малчдыг бодлогоор дэмжих
- 6.8 Малын нутагшмал өвчнийг судалж, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- 6.9 Хөдөө аж ахуйн материаллаг баазыг сайжруулах чиглэлд анхаарч ажиллана.
- 6.10 Мал аж ахуйн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх
- 6.11 Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварыг бий болгох
- 6.12 Малчдын боловсролыг нэмэгдүүлэх
- 6.13 Төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх
- 6.14 Төрөл бүрийн жимсний мод тариалах иргэд, хувийн хэвшлийн санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.15 Малчин иргэдийн малын хөлийн бууцанд ногоон тэжээлийн ургамал тариалах төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 6.16 Хүнсний аюулгүй байдлын стандартыг бүх салбарт мөрдүүлж, хүн амыг баталгаат хүнсээр хангана
- 6.17 Багуудын хүн малын усны худгуудад эрүүл ахуйн бүс тогтоож хүн амыг стандартын шаардлага хангасан усаар хангах асуудлыг шийдвэрлүүлнэ.

➤ **Долоо: Байгаль орчин**

- 7.1 Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулан, нөхөн сэргээж, хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ
- 7.2 Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, бусад хохирлоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, байгалийн баялгийн үр нөлөөг нэмэгдүүлнэ
- 7.3 Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлж Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд анхаарч мод үржүүлгийн газар байгуулах иргэд, ААН-ийг дэмжиж газар олголтыг шийдвэрлэнэ.
- 7.4 Ховор нэн ховордож буй амьтдын тархац нутгийг тогтоож, тоо толгойг нэмэгдүүлэх
- 7.5 Усны нөөцийг хамгаалж, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх
- 7.6 Хогийн төвлөрсөн цэгийг тохижуулж хоёрдогч түүхий эдийг борлуулах боловсруулах санал санаачилгыг дэмжинэ
- 7.7 Булаг шанд усны нөөцийг хамгаалж, бэлчээрийн худгуудын ашиглалтыг сайжруулах

➤ **Найм: Аялал жуулчлал**

- 8.1 Аялал жуулчлалыг орлогын эх үүсвэр болгон хөгжүүлэх



000000000002

8.2 Орон нутгийн онцлог, нөөцөд тулгуурлан аймаг бүсийн хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх

8.3 Гадаадын жуулчид, дотоодын аялагчдад зориулсан нутгийн брэнд бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэн хөгжүүлэх

8.4 Түр буудаллах болон алжаал тайлах цэгүүдийг байгуулах байршлыг тогтоох

8.5 Уламжлалт ёс заншил, малчдын ахуй амьдралд суурилсан аялал жуулчлалын үйлчилгээг бий болгох

➤ **Ес: Газрын харилцаа**

9.1 Ил тод байдлыг хангаж иргэдийн газар өмчлөлийг эрчимжүүлж газрыг эдийн замын эргэлтэд оруулна

9.2 Газар эзэмшил хамгаалалтыг сайжруулж, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлнэ

9.3 Бэлчээрийн эдэлбэр газрыг сэлгэх өнжөөх, даац багтаамжид тохируулан ашиглах, төлөвлөлтийг сайжруулж хэрэгжүүлэх

9.4 Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар Сумын газар зохион байгуулалтын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах

➤ **Арав: Дэд бүтэц**

10.1 Эгийн голын төмөр бетонон гүүрийг бий болгох ажлын ТЭЗҮ-г ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийж, гүйцэтгэлийг улсын төсөвт тусгуулахаар ажиллана.

10.2 Сумын төвийг Мөрөн-Хатгалын чиглэлийн хатуу хучилтай замтай холбох ажлыг улсын төсөвт тусгуулахаар ажиллана.

10.3 Орон нутгийн чанартай зам, даваа, гүүрийг засаж сайжруулах асуудлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх

10.4 Сумын төвийн доторх авто замыг нэмэгдүүлж явган хүний гэрэлтүүлэгтэй болгоно.

10.5 Үүрэн холбоо операторуудын сүлжээний өргөтгөл хийх, багуудыг найдвартай холбоогоор хангах асуудлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.

10.6 Дулаан хангамжийн хүчин чадлыг сайжруулж, гудамж айл өрхийн дулаанд холбогдох боломжоор хангах асуудлыг шийдвэрлүүлнэ.

10.7 Даахийн аманд дэд станц буулгаж, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг цэг бий болгох

10.8 Нэгдүгээр багийн Улаан толгойд, Далангийн Хад толгойд гүний худаг гаргах

10.9 Харганы талд гүний худаг гаргах

10.10 Нэгдүгээр багт Улаан толгойд мал угаалгын ванн барих

10.11 Орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх

10.12 ЗДТГ-ын хуучин цагаан байрыг засварлаж төрийн албан хаагчдын байр болгох

10.13 Багийн төвүүдэд Залуусын хөгжлийг дэмжих төвтэй болгох

НИЙТ : ЗОРИЛТ -10, ЗААЛТ- 107

АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО



00090603.5